МОНГОЛ УЛСЫН
ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2013 оны 6 сарын 24 өдөр Дугаар 117 Улаанбаатар хот

"Хөвсгөл далайн эзэд" ТББ болон иргэн
Д.Мягмарчулуун, Ж.Базаррагчаа, О.Даваажав, Т.Даваачулуун
нарын нэхэмжлэлтэй захиргааны хэргийн тухай

Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааныг Танхимын тэргүүн О.Зандраа даргалж, шүүгч Х.Батсүрэн, М.Батсуурь, Ч.Тунгалаг, Ц.Сумъяа нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн дарга Т.Болортуяа, нэхэмжлэгч Б.Баярмаа, нэхэмжлэгчийн өмгөөлөгч Ш.Жаргалсайхан нарыг оролцуулан Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 2013 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 36 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны 2013 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 138 дугаар магадлалтай "Хөвсгөл далайн эзэд" ТББ болон иргэн Д.Мягмарчулуун, Ж.Базаррагчаа, О.Даваажав, Т.Даваачулуун нарын нэхэмжлэлтэй Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтэст холбогдох захиргааны хэргийг нэхэмжлэгч нарын итгэмжлэгдсэн төлөөлөгч, нэхэмжлэгч "Хөвсгөл далайн эзэд" ТББ-ын тэргүүн Б.Баярмаа нарын хяналтын журмаар гаргасан гомдлоор, шүүгч Ц.Сумъяагийн илтгэснээр хянан хэлэлцэв.

Нэхэмжлэгч Д.Мягмарчулуун, Ж.Базаррагчаа, О.Даваажав, Т.Даваачулуун нар болон "Хөвсгөл далайн эзэд" ТББ шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ: Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Туяа багийн нутаг дэвсгэр Бүрэнхааны орчимд ашигт малтмалын дор дурдсан тусгай зөвшөөрлүүдийг олгосон Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн шийдвэрүүд нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.7-д дурдсан илт хууль бус акт тул мөн хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.3-д заасны дагуу илт хүчин төгөлдөр бусад тооцож, Талст маргад ХХК-д 2007 оны 8 дугаар сарын 14-ний өдөр олгогдсон 12633Х, 12634Х, 12635Х, 12636Х, 12637Х, 12638Х тоот хайгуулын тусгай зөвшөөрлүүд, мөн 11428А, 3999А тоот ашиглалтын лицензүүдийг Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.4 дэх заалтын дагуу цуцлах арга хэмжээг авахыг Ашигт малтмалын газрын Геологи, уул уурхай, кадастрын хэлтсийн даргад даалгах шийдвэрийг гаргаж өгнө үү.

1. Хайгуулын 6 лицензүүдийн хувьд:

Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.4-т "Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж, нөөцийг нь тогтоон улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн ордод хайгуулын тусгай зөвшөөрөл олгохгүй" гэсэн зохицуулалт бий. Гэтэл Бүрэнхааны фосфоритын ордод 1981-1984 онд хийсэн хайгуулын ажлын үр дүнгээр тогтоогдсон

протокол хүчин төгөлдөр байгаа бөгөөд АМГТХЭГ-ын Геологи мэдээллийн төвд 3817 тоот тайлангаар бүртгэгдсэн байдаг. Уг ордын талбайн хил хүрээг тогтоох ажлын үр дүн гараагүй, ордын хил хүрээг геологи, уул уурхайн кадастрын зураг тусгаж баталгаажуулаагүй байхад тусгай зөвшөөрлүүдийг хууль зөрчиж олгосон байна.

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуулийн 33 дугаар зүйлийн дагуу жил бүр хайгуулын ажлын зардлын доод хэмжээг хангаж ажиллах үүрэгтэй бөгөөд үүнийг зөрчсөн тохиолдолд мөн хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.4-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцлах нөхцөл бүрддэг. Гэтэл дээрх тусгай зөвшөөрлүүдийг 2007 онд авснаас хойш одоог хүртэл хайгуулын ажлыг огт хийгээгүй, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс ирүүлсэн хайгуулын ажлын тайлангуудын бодитой эсэх нь баталгаажаагүй байдаг. Байдал ийм атал эдгээр тусгай зөвшөөрлүүд нь одоог болтол хүчин төгөлдөр байсаар байгаа нь Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн дагуу цуцлагдах үндэслэл бүрдэж байна.

2. Ашиглалтын 2 лицензүүдийн хувьд:

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, Ашигт малтмалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.7 дахь заалтын дагуу ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл авахад энэхүү байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хавсаргах ёстой. Гэтэл тус компанид олгогдсон ашиглалтын лицензүүдийн хувьд "Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ" огт хийгдээгүй байна. Фосфоритыг байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө багатайгаар олборлох технологийн байдал шаардлага хангахгүй байгаа өнөө үед байгаль орчинд нөлөөлөх байдлын ямар нэг үнэлгээгүйгээр энэ төрлийн ашигт малтмалыг ашиглах эрх буюу лицензийг олгох нь холбогдох хууль тогтоомж болон "Хөвсгөл далайн эзэд" хөдөлгөөний гишүүд болон Туяа багийн иргэдийн Үндсэн хуулиар олгогдсон эрхийг ноцтой зөрчиж буй хэрэг мөн гэжээ.

Хариуцагч Ашигт малтмалын газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтсээс шүүхэд гаргасан хариу тайлбартаа: Ашигт малтмалын хайгуулын 12636Х, 12637Х, 12638Х, 12633Х, 12634Х, 12635Х дугаартай тусгай зөвшөөрлүүдийн талаар:

"Талст маргад" ХХК-иас ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүсэж дараах газруудад өргөдөл гаргасныг хүлээн авч бүртгэн өргөдлүүдийг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан. Ингээд "Талст маргад" ХХК-ийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлүүдийг Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-д "энэ хуулийн 19.1.3-т заасан анхан шатны шүүлт хийсний дараа хүсэлтэд дурдсан талбай нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хайгуулын тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон буюу түрүүлж ирүүлсэн өргөдөлд дурдсан талбайтай давхцаж байгаа эсэхийг тогтоох" гэж заасны дагуу 19163Х, 19160Х, 19162Х дугаартай өргөдлүүдийг 2007 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр, 19323Х, 19325Х, 19324Х дугаартай өргөдлүүдийг 2007 оны 4 дүгээр сарын 20-ны өдрүүдэд хүлээн авч, тухайн өргөдлүүдэд тусгагдсан солбицлуудын дагуу зураг зүйн шүүлт хийсэн ба уг шүүлтээр ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн дээрх өргөдлүүдэд дурдагдсан талбай нь мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-т заасан талбайтай давхцаагүй болох нь тогтоогдсон.

Иймээс Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.2 дахь хэсэгт "хүсэлтэд дурдсан талбай нь энэ хуулийн 19.1.4-т заасан талбайтай давхцаагүй бол

хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтойг мэдэгдэх" гэж заасны дагуу "Талст маргад" ХХК-д мэдэгдэж, улмаар мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т "Энэ хуулийн 19.2.2, 19.2.5-д заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох боломжтой гэж үзсэн бол төрийн захиргааны байгууллага нь энэ талаар тухайн аймаг, Нийслэлийн Засаг даргад бичгээр мэдэгдэх бөгөөд түүнд энэ хуулийн 17.1-д заасны дагуу хийгдсэн талбайн зургийг хавсаргана" гэж заасны дагуу 2007 оны 5 дугаар сарын 10-ны өдөр 19163Х, 19160Х, 19162Х, 19323Х, 19325Х, 19324Х дугаартай өргөдлүүдэд Хөвсгөл аймгийн Засаг даргаас санал авах тухай мэдэгдлүүдийг хүргүүлсэн.

Хөвсгөл аймгийн Засаг дарга хуульд заасан 30 хоногийн дотор тусгай зөвшөөрөл олгохыг дэмжсэн, эсвэл хуульд заасны дагуу татгалзсан хариуг Ашигт малтмалын газарт өгөөгүй учраас Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5-т "Аймаг, нийслэлийн Засаг дарга зөвхөн хуульд заасан үндэслэлээр хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан хариу өгч болно" гэсэн заалтыг үндэслэн 2007 оны 8 дугаар сарын 10-ны өдөр 1996 дугаартай шийдвэрээр ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлүүдэд 12363Х, 12637Х, 12638Х, 12633Х, 12634Х, 12635Х дугаартай тусгай зөвшөөрлүүдийг олгохоор шийдвэрлэсэн. Иймд тусгай зөвшөөрөл олгосон 2007 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 1996 дугаартай шийдвэр нь эрх зүйн үндэслэлгүй, илт хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэлгүй болно.

Ашигт малтмал ашиглалтын 3999А, 11428А дугаартай тусгай зөвшөөрлүүдийн талаар:

"Талст маргад" ХХК-иас 2001 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутагт Бүрэнхаан-1 нэртэй газарт ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргасныг хүлээн авч, өргөдлийн бүртгэлийн 5019А дугаарт бүртгэсэн. 1997 оны 6 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу 2001 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр 5018А, 5019А дугаартай ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл авахыг хүссэн өргөдлүүдэд тусгагдсан талбайд зураг зүйн болон компьютерийн тусламжтайгаар шүүлт хийж, ямар нэгэн давхцалгүй болохыг тогтоосон. Мөн "Талст маргад" ХХК-ийн ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэж гаргасан 5019А дугаарт бүртгэгдсэн өргөдөлд тусгагдсан талбай нь тус компанийн 2832Х дугаартай хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд хамрагдаж байгаа нь онцгой эрхээр ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох боломжтой байсан. Иймхүү "Талст маргад" ХХК-ийн 3999А дугаартай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгосон үйл ажиллагаа хуульд заасан журмын дагуу явагдсан.

Мөн "Талст маргад" ХХК-аас 2005 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутагт Бүрэн-уул нэртэй газарт ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргасныг хүлээн авч, өргөдлийн бүртгэлийн 17341А дугаарт бүртгэж, өргөдөлд тусгагдсан талбайд зураг зүйн болон компьютерийн тусламжтайгаар шүүлт хийхэд ямар нэгэн давхцалгүй болох нь тогтоогдсон. Түүнчлэн тус талбай нь тус компанийн 2832Х дугаартай хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд хамрагдаж байгаа нь онцгой эрхээр ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох боломжтой байсан.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу ашигт малтмал хайх ашиглах үйл ажиллагаа явуулахад тухайн аймгийн Засаг даргын саналыг авсан байх шаардлагатай тул 2005 оны 12 дугаар сарын 28-ны

өдөр 7-10508 дугаартай мэдэгдэл хүргүүлсэн. Үүний хариуд Хөвсгөл аймгийн Засаг дарга 2006 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр ирүүлсэн саналдаа, өргөдлийн бүртгэлийн 17341А дугаарт бүртгэгдсэн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд тусгагдсан талбайд ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохыг дэмжсэн хариу ирүүлсэн. Иймээс "Талст маргад" ХХК нь ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг төлсөн, Хөвсгөл аймгийн Засаг даргаас дэмжсэн санал ирүүлсэн учраас Ашигт малтмалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу 2006 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 155 дугаартай шийдвэрээр ашигт малтмал ашиглалтын 11428А дугаартай тусгай зөвшөөрлийг олгосон.

Ашигт малтмалын хайгуулын 12633Х, 12634Х, 12635Х, 12636Х, 12637Х, 12638Х дугаартай тусгай зөвшөөрлүүдийн хайгуулын ажлын зардлыг доод хэмжээг баталгаажуулсан талаар,

"Талст маргад" ХХК-иас хуульд заасны дагуу гаргавал зохих мэдээ, тайлан, төлөвлөгөөг хугацаанд нь гаргаж Ашигт малтмалын газарт ирүүлж байсан бөгөөд 2008-2009 онд хайгуулын ажлын зардлыг гаргаж, Ашигт малтмалын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2-т заасны дагуу дээрх компанийн хайгуулын ажилд зарцуулсан зардлыг Ашигт малтмалын газраас баталгаажуулсан болно. Тус компанийн хайгуулын ажилд зарцуулсан зардал нь тухайн жилд хийж гүйцэтгэх хайгуулын ажлын зардлын доод хэмжээнээс их байгаа тул Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.4 дэх хэсэгт зааснаар цуцлах үндэслэлгүй байна. Иймд нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, 2001 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 760 дугаартай, 2006 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 155 дугаартай, 2007 оны 8 дугаар сарын 14-ны өдрийн 1996 дугаартай шийдвэрүүдийг хэвээр үлдээж өгнө үү гэжээ.

Гуравдагч этгээд “Талст маргад” ХХК-иас шүүхэд гаргасан хариу тайлбартаа: Ашигт малтмалын хайгуулын 12633Х, 12634Х, 12635Х, 12636Х, 12637Х, 12638Х дугаартай тусгай зөвшөөрлүүдийн хувьд:

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын "Орон нутгийн зарим хэсгийг тусгай хэрэгцээнээс чөлөөлөх тухай" иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2007 оны 2/01 тоот тогтоол гарсан. Үүнд манай ашигт малтмал хайгуулын 12633Х, 12634Х, 12635Х тусгай зөвшөөрөлд заасан газар хамаарна. Манай компани нь 2007 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүсэж Ашигт малтмалын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан журмын дагуу зохих баримт бичгийг хавсарган өргөдлийг Ашигт малтмалын газарт гаргасны дагуу өргөдлүүдэд тусгагдсан солбицлуудын дагуу зураг зүйн шүүлтийг хийсэн ба өргөдлүүдэд тусгагдсан талбай нь Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-т заасан талбайтай давхцаагүй болох нь тус шүүлтээр тогтоогдсон.

Манай "Талст Маргад" ХХК нь Ашигт малтмалын тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу тусгай зөвшөөрлүүдийг авсан болно. Иймээс нэхэмжлэгчийн дурдсанаар илт хүчин төгөлдөр гэж үзэх үндэслэл байхгүй юм. "Талст Маргад" ХХК нь ашигт малтмалын хайгуулын 12633Х, 12634Х, 12635Х, 12636Х, 12637Х, 12638Х тусгай зөвшөөрлүүдийг холбогдох хууль, журмын дагуу авснаас хойш жил бүр хуулийн дагуу гаргавал зохих мэдээ, тайлан, төлөвлөгөө, хайгуулын ажлын зардлын доод хэмжээг баталгаажуулж цаг хугацаанд нь Ашигт малтмалын газар хүргүүлсэн

ба жил бүр Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу хайгуулын ажилд зарцуулсан зардлын доод хэмжээ, түүнийг зохих байгууллагаар нь жил бур баталгаажуулан ажиллаж ирсэн. Иймээс нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлага нь ямар ч үндэслэлгүй байна.

Ашигт малтмал ашиглалтын 3999А, 11428А дугаартай тусгай зөвшөөрлүүдийн хувьд:

"Талст Маргад" ХХК нь 2001 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутагт Бүрэнхаан-1 нэртэй газарт ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргасныг зохих байгууллага нь хүлээн авч 5019А өргөдлийн бүртгэлийн дугаарт бүртгэсэн, 1997 оны 6 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хуулийн 17, 18 дугаар зүйлд заасны дагуу зохих бичиг баримтыг бүрдүүлж бүртгүүлсэн. Геологи, уул уурхайн кадастрын алба нь хууль, журмын дагуу шүүлт хийсэн бөгөөд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүсэж гаргасан 5019А бүртгэлийн дугаарт бүртгэгдсэн өргөдөлд тусгагдсан талбай нь манай компанийн 2832Х дугаартай хайгуулын зөвшөөрөлтэй талбайд хамрагдаж байсан нь онцгой эрхээр ашиглалтын тусгай зөвшөөрөл авах эрхтэй байсан.

1997 оны 6 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6.1 дэх хэсэгт зааснаар хайгуулын лиценз эзэмшигч нь "уг лицензээр олгогдсон талбайд ашигт малтмал ашиглах лиценз авахаар өргөдөл гаргасан тохиолдолд онцгой эрхийнх нь дагуу уурхайн эдэлбэр олгож, ашигт малтмал ашиглах лицензийн эхний жилийн төлбөрийг энэ хуульд заасан хугацаанд төлүүлэх" гэж заасны дагуу манай компанид 2001 оны 12 дугаар сарын 03-ны өдөр төлбөр төлөх мэдэгдэл ирүүлсэн. Энэхүү мэдэгдлийн дагуу манай компани ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг төлж 2001 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 760 дугаартай шийдвэрээр ашигт малтмал ашиглалтын 3999А дугаартай тусгай зөвшөөрлийг Ашигт малтмалын газраас олгосон.

Мөн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүсэж гаргасан 17341А бүртгэлийн дугаарт бүртгэгдсэн өргөдөлд тусгагдсан талбай нь манай компанийн 2832Х дугаартай хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд хамрагдаж байсан нь онцгой эрхээр ашиглалтын тусгай зөвшөөрөл авах эрхтэй байсан ба хуулийн дагуу манай компани ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг төлж 2006 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 155 дугаартай шийдвэрээр ашигт малтмал ашиглалтын 11428А дугаартай тусгай зөвшөөрлийг Ашигт малтмалын газраас олгосон.

Ингэхээр нэхэмжлэгчийн нэхэмжлэлд дурдсанаар Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ нь огт хийгдээгүй гэсэн нь үндэслэлгүй. 1997 оны Ашигт малтмалын тухай хуулиар Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдэх гэсэн зохицуулалт байгаагүй. Иймд нэхэмжлэгч нарын нэхэмжлэл нь хууль зүйн хувьд үндэслэлгүй тул бүхэлд нь хэрэгсэхгүй болгож өгнө үү гэжээ.

Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 2013 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 36 дугаар шийдвэрээр, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5-д заасныг баримтлан нэхэмжлэгч Д.Мягмарчулуун нарын 4 иргэний "ГУУКХ-ийн даргын Талст маргад ХХК-д олгосон 12000, 12000Х

тусгай зөвшөөрлийг цуцлахыг даалгах нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4, 40 дүгээр зүйлийн 40.2, 56 дугаар зүйлийн 56.1.4, 60 дугаар зүйлийн 60.4, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т заасныг баримтлан Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын 2001 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 760 дугаар шийдвэрийн Талст маргад ХХК-д 3999 А тоот, 2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 155 дугаар шийдвэрийн Талст маргад ХХК-д 11428А тоот ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлүүдийг тус тус олгосон хэсгийг хэргийн нөхцөл байдлыг тодруулсны дараа дахин шинэ захиргааны акт гаргах хүртэл хугацаагаар түдгэлзүүлж, нэхэмжлэгч Д.Мягмарчулуун нарын 4 иргэн болон Хөвсгөл далайн эзэд ТББ-ын гаргасан нэхэмжлэлийн үлдэх хэсгийг хэрэгсэхгүй болгож, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2-т зааснаар хариуцагч нь Талст маргад ХХК-ний хийлгэсэн ашигт малтмал ашиглах үйл ажиллагаа нь тухайн орчинд амьдарч буй хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хэрхэн нөлөөлөх эсэх талаар ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний үндсэн дээр, тухайн талбайд ашигт малтмал ашиглах үйл ажиллагаа явуулах нь холбогдох байгаль орчны болон бусад хууль тогтоомжид нийцэх эсэх, бусдын эрхэд нөлөөлөх эсэхийг харгалзан, дахин шинэ акт гаргах замаар шүүхийн энэхүү шийдвэрийг биелүүлж шийдвэрлэжээ.

Нэхэмжлэгч нарын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ш.Жаргалсайхан, "Хөвсгөл далайн эзэд" ТББ-ын тэргүүн Б.Баярмаа нарын гомдлоор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2013 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 138 дугаар магадлалаар: Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 2013 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 36 дугаар шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгч "Хөвсгөл далайн эзэд" ТББ болон нэхэмжлэгч нарын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ш.Жаргалсайхан нарын давж заалдах гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэжээ.

Нэхэмжлэгч нарын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ш.Жаргалсайхан, "Хөвсгөл далайн эзэд" ТББ-ын тэргүүн Б.Баярмаа нар хяналтын журмаар гаргасан гомдолдоо: "...Давж заалдах шатны шүүх Алаг-Эрдэнэ, Түнэл сумдын нутагт ашигт малтмалын хайгуулын 12636Х, 12638Х дугаартай тусгай зөвшөөрлүүдийн талаар Бүрэнтогтох сумын иргэд нэхэмжлэл гаргасныг "нэхэмжлэгч нарын эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөөгүй, нэхэмжлэл гаргах эрхгүй этгээдүүд нэхэмжлэл гаргасан" гэж дүгнэсэн байдаг. Гэтэл Бүрэнтогтох сумын нутагт байгаа 12633Х, 12634Х, 12635Х, 12637Х хайгуулын тусгай зөвшөөрлийн талаар тодорхой дүгнэлт хийгээгүй байгаагаас үзвэл нэхэмжлэх эрхийг хүлээн зөвшөөрч байгаа байдал ажиглагддаг. Гэтэл давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгож байгаа нь Монгол улсын үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасныг зөрчиж байна. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2"Эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалах эрхтэй., 16.1.10 ... сайн дурааараа эвлэлдэн нэгдэх, 16.1.12-т төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх, 17.2 .... байгаль орчноо хамгаалах нь журамт үүрэг мөн гэсэн эрх, үүргээ хэрэгжүүлэхэд иргэний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хангаж, хамгаалах баталгаа болсон шүүх үүргээ гүйцэтгэхгүй байна гэж үзэж байна

...Хөвсгөл далайн эзэд ТББ-ын нэхэмжлэх эрхийн тухайд: ^Хөвсгөл далайн эзэд" ТББ нь Хөвсгөл нуурын сав газрын эко систем болон тэнд амьдарч байгаа иргэдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдсэн үйл ажиллагааг явуулах зорилгоор нутгийн иргэд сайн дураар эвлэлдэн нэгдэж ХЗДХЯ-наас албан ёсоор гэрчилгээ авч дүрмийн зорилгод нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд нэхэмжлэл гаргах эрхтэй гэж үзэх үндэстэй.Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т " Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн зөрчилтэй тэмцэх болон байгаль орчинд хортой нөлөөлсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг шаардах,... шүүхэд нэхэмжлэл гаргах", мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1-д"Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах...", Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "... мөн хуулийн 6.1-д заасан хугацаанд захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй" гэж заасан. Энд хугацааны асуудлыг хуульчилсан болохоос эрх,эрх ашгийн сонирхлын асуудлыг заагаагүй нь ЗХШХШ тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5-д заасныг баримталсан нь хуулийг буруу хэрэглэсэн гэж үзэж байна. Нийслэлийн Захиргааны Хэргийн Шүүх хэргийн нэхэмжлэлийг хүлээн аваад нэхэмжлэх эрхтэй эсэх, захиргааны хэргийг шүүхэд харъяалах маргаан эсэх, хөөн хэлэлцэх хугацаа зэргийг судлан үзэж хэрэг үүсгэх эсэхийг шийддэг. Үүний дагуу судлан үзсэний үндсэн дээр хэрэг үүсгэн 2 жил гаран хянан шийдвэрлэх ажиллагаа явагдсан гэж ойлгогдож байгаа. Хэрэв тийм биш байсан бол хэрэг үүсэхээс өмнө нэхэмжлэл хүлээн авахаас татгалзах боломжтой байсан...

...2006 оны АМТХ-н 25.1.7-д ашиглалтын тусгай зөвшөөрөл авахаас өмнө үнэлгээ хийхийг заасан бөгөөд уг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд "2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөхөөс өмнө тухайн үед мөрдөгдөж байсан хууль тогтоомжийн дагуу олгогдсон хайгуулын болон ашиглалтын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл /лиценз/-ийг шинээр батлагдсан хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 5 сарын хугацаанд уг хуульд заасан журмын дагуу шинэчлэн бүртгэнэ." гэж заасан.Үүний дагуу дээрх тусгай зөвшөөрлүүд шинэчлэгдэн бүртгэгдсэн байх учиртай. Гэтэл шинэ хуулиар батлагдсан журам буюу үнэлгээ хийлгэсэн байх шаардлагыг мөн л хангаагүй гэдэг нь БОАЖЯ-наас шүүхэд ирүүлсэн тодорхойлолтоор (220х) нотлогдож байсан. Шинэчлэн бүртгүүлэхэд БОНБҮ хийлгэх шаардлагатай байсан гэдгийг ҮХС-ын тушаалаар АМГТХЭГ-ын Кадастрын бүртгэлийн төвийн уйл ажиллагаанд шалгалт хийхээр томилогдсон Ажлын хэсгийн 2007 оны 7 дугаар сарын 16-ны дүгнэлтээр мөн харагдаж байгаа.(143-144х). Өөрөөр хэлбэл 1997 оны хуулийн дагуу олгогдсон АТЗ-уудыг 2006 оны хуулийн дагуу шинэчлэн бүртгэхэд БОНБҮ хийлгэсэн эсэхийг харгалзан үзэх ёстой. Гэтэл Талст маргад компанийн ашиглалтын тусгай зөвшөөрлийг шинэчлэн бүртгэхэд хуулийн энэ заалтыг хэрэгжүүлээгүй байна. Үүнийг ажлын хэсэг зөрчил мөн хэмээн дүгнэсэн байдаг. Ажлын хэсэг дүгнэлт №1, №2-тоо Кадастрын бүртгэлийн төв АМТХ-ийн холбогдох заалтуудыг байнга зөрчдөг нь хэвийн үзэгдэл болсон гэсэн байна...

...Иймд давж заалдах шатны шүүхийн 2013 оны 4 дүгээр сарын 29-ний 138

ХЯНАВАЛ:

Нэхэмжлэгч "Хөвсгөл далайн эзэд" ТББ болон иргэн Д.Мягмарчулуун, Ж.Базаррагчаа, О.Даваажав, Т.Даваачулуун нар Ашигт малтмалын газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын 2001 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 760, 2006 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 155 дугаар шийдвэрийн "Талст маргад" ХХК-д 3999А, 11428А дугаар ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосныг илтэд хүчин төгөлдөр бусад тооцуулах, Мөн тус компанид 2007 оны 8 дугаар сарын 14-ны өдөр олгосон 12633Х-12638Х дугаар ашигт малтмалын хайгуулын 6 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож цуцлахыг Ашигт малтмалын газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргад даалгах шаардлага бүхий нэхэмжлэлийг гаргажээ.

1. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаар:

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутаг дэвсгэрт Ашигт малтмалын газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын /хуучин нэрээр/ 2001 оны 760 дугаар шийдвэрээр 52 га, 2006 оны 155 дугаар шийдвэрээр 634 га талбай бүхий уурхайн эдэлбэр газарт ашигт малтмалын 3999А, 11428А дугаар ашиглалтын тусгай зөвшөөрлийг "Талст маргад" ХХК-д олгосон байна.

Анхан шатны шүүх "дээрх тусгай зөвшөөрлүүдийг олгох үед Ашигт малтмалын тухай /2006 оны/ хууль батлагдаагүй байсан, тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Ашигт малтмалын тухай /1997 оны/ хуулийн 18 дугаар зүйлд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн этгээд өргөдөлдөө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг заавал хавсаргах талаар заагаагүй тул хариуцагчийг хууль зөрчсөн гэж үзэж, тусгай зөвшөөрлүүдийг анхнаасаа илт хүчин төгөлдөр бусад тооцох үндэслэлгүй байна" гэж дүгнэлт хийсэн нь буруу болжээ.

Учир нь, анхан шатны шүүх уг асуудлыг нарийвчлан зохицуулсан хэрэглэвэл зохих Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай /1998 оны/ хуулийг хэрэглээгүйн гадна хууль дээдлэх зарчмыг хэрэгжүүлээгүй байна.

Тухайлбал, "Талст маргад" ХХК-д ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохоос өмнө Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай /1998 оны/ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн "Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ нь төслийг хэрэгжүүлж эхлэхийн өмнө хийгдсэн байна" гэсэн заалтыг 2001 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ нь ашигт малтмал ашиглах, газар эзэмших эрх авах болон төсөл хэрэгжүүлж эхлэхийн өмнө хийгдсэн байна" гэж өөрчлөн найруулсан байхад шүүх хариуцагчийг дахин шинэ акт гаргах хүртэл хугацаагаар маргаан бүхий захиргааны актыг түдгэлзүүлсэн нь хууль зүйн үндэслэлгүй юм.

Гуравдагч этгээд "Талст маргад" ХХК нь ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг авахаас өмнө болон хойш Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж байгаагүй болох нь хариуцагчийн тайлбар, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2011 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 6/1721 дүгээр албан бичгээр батлагдаж байна.

Түүнчлэн Ашигт малтмалын тухай /1997 оны/ хуулийн 30, 31 дүгээр зүйлд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх талаар зохицуулсан заалтуудыг гуравдагч этгээд зөрчиж, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгээгүй

2. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлүүдийн талаар:

Ашигт малтмалын газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын 2007 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 1996 дугаар шийдвэрээр "Талст маргад" ХХК-д Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутагт 12633Х, 12634Х, 12635Х, 12637Х, Алаг-Эрдэнэ, Түнэл сумдын нутагт 12636Х, 12638Х дугаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгосон байна.

Монгол улсын иргэн эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй болохыг Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2-т тусгайлан заажээ.

Нэхэмжлэгч "Хөвсгөл далайн эзэд" ТББ-ын болон Д.Мягмарчулуун нарын иргэд нэхэмжлэлдээ "Бидний өвөлжөө, хаваржааны газар, мөн хядгийн гол байрладаг, хядгийн рашаан, түүх соёлын дурсгалт зүйлсийн газар нутагт хайгуулын тусгай зөвшөөрөл олгож, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчиж байна" гэж маргаан үүсгэсэн байна.

"Хөвсгөл далайн эзэд" ТББ-ын дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1-д тус байгууллагын зорилго, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлохдоо "Хөвсгөл далайн эзэд" хөдөлгөөн ТББ-ын эрхэм зорилго нь: "Иргэдийн оролцоотойгоор Хөвсгөл нуурын ай сав газрын унаган төрхийг хэвээр хадгалж, нутгийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хамгаалахад оршино" гэснээс үзэхэд маргаан бүхий хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг олгосон Бүрэнтогтох, Алаг-Эрдэнэ, Түнэл сумдын нутагт амьдарч байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалж нэхэмжлэл гаргасныг буруу гэж үзэх боломжгүй юм.

Түүнчлэн уг төрийн бус байгууллага нь "Байгаль орчныг хамгаалах байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, тогтвортой хөгжлийг хангах, чиглэлээр иргэдийн эрх ашиг, сонирхлоороо бий болгосон аливаа үүсгэл санаачилга, оролцоо, үйл ажиллагааг дэмжих, нийтийн эрх ашгийг хамгаалахын төлөө ажиллах" гэж дүрэмдээ тусгажээ.

Нэхэмжлэгч Д.Мягмарчулуун нарын малчин иргэдийн өвөлжөө, хаваржааны нутаг, мал бэлчээрлэх газарт нь ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгож, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироосон байна.

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутаг Бүрэнхааны фосфоритын орд газарт 1981-1984 онд улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж, нөөцийг нь тогтоон уг орд газрын хил хүрээний дотор ил задгай олборлолтод үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах бэлтгэл ажлыг хангагдсанд тооцсон нь БНМАУ, ЗСБНХУ-ын Ашигт малтмалын нөөцийн улсын комиссын 1985 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн хамтарсан хурлын протокол, Ашигт малтмал, Газрын тосны хэрэг эрхлэх газрын Геологийн мэдээллийн төвд 3817 дугаар тайлангаар бүртгэгдсэн зэргээр тогтоогдсон байна.

Үйлдвэр худалдааны яамнаас томилогдсон ажлын хэсгийн дүгнэлтэд "Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтсийн даргын 2007 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 1996 дугаар шийдвэрээр Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох, Алаг-Эрдэнэ сумдын нутагт 1932 га талбайнуудыг "Талст маргад" ХХК-д олгосон нь стратегийн ач холбогдол бүхий Бүрэнхааны фосфоритын ордын хил хүрээг тогтоох ажлын үр дүн гараагүй байхад тусгай зөвшөөрөл олгосон нь буруу байна" гэжээ.

Эдгээрээс үзвэл Ашигт малтмалын газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн дарга нь улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж, нөөцийг нь тогтоон, улсын бүртгэлд бүртгүүлсэн фосфоритын орд газарт дахин хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг олгож, Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.4 дэх хэсгийн "Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж, нөөцийг нь тогтоосон, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн ордод хайгуулын тусгай зөвшөөрөл олгохгүй" гэснийг зөрчсөн байна.

Гэтэл шүүхүүд хариуцагчийн дээрх хууль зөрчсөн шийдвэрийн улмаас нэхэмжлэгч нарын эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн гэж үзэх үндэслэлгүй гэж дүгнэсэн нь шударга ёсны зарчим болон хэргийн бодит байдалтай нийцэхгүй байна.

Мөн Бүрэнтогтох сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2011 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн "Тусгай хамгаалалтад авах тухай" 54 дүгээр тогтоолоор сумын нийт нутаг дэвсгэрийг тусгай хамгаалалтад авахаар шийдвэрлэсэн, "Талст маргад" ХХК-д олгогдсон 3999А, 11428А, 12633Х, 12634Х, 12635Х, 12637Х тусгай зөвшөөрлүүдийн ашиглалт болон хайгуул хийх талбай нь дээрх тогтоолд хамаарч байгааг тэмдэглэх нь зүйтэй юм.

Төрийн захиргааны эрх бүхий байгууллагын буруутай үйл ажиллагааны улмаас Бүрэнхааны фосфоритын орд газарт ашигт малтмал ашиглах болон хайгуул хийх тусгай зөвшөөрлүүдийг "Талст маргад" ХХК-д олгосны улмаас нэхэмжлэгч нарын эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн болох нь хавтаст хэргийн I-145, II-13, II-128-136 дугаар талд авагдсан бичмэл нотлох баримтуудаар нотлогджээ.

Анхан болон давж заалдах шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ хэрэгт цугларсан бөгөөд шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн нотлох баримтуудыг тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв, эргэлзээгүй талаас нь үнэлээгүй, нэхэмжлэлийн шаардлагад дурьдагдсан маргаан бүхий захиргааны актын үндэслэлийг хуульд нийцүүлэн хянаж, дүгнэлт өгөөгүйгээс шүүхийн шийдвэр, магадлал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуульд заасан шаардлагыг хангаж чадаагүй байна.

Шүүхүүд Ашигт малтмалын тухай болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиудын холбогдох зүйл, заалтуудыг буруу тайлбарлан хэрэглэж, хэргийг хянан шийдвэрлэсэн байх тул анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, нэхэмжлэгч нарын нэхэмжлэлийн шаардлагыг хангах нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэв.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 176 дугаар зүйлийн 176.2.2-т заасныг удирдлага болгон ТОГТООХ НЬ:

1. Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 2013 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 36 дугаар шийдвэрийн тогтоох хэсгийн 1, 3, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2013 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 138 дугаар магадлалын тогтоох хэсгийн 1 дэх заалтыг тус тус хүчингүй болгож, шийдвэрийн 2 дахь заалтыг 1 болгон "1. Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.4

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай /1998 оны/ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.3, 70.2.4-т заасныг баримтлан нэхэмжлэгч нарын нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, Ашигт малтмалын газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын 2001 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 760, 2006 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 155 дугаар шийдвэрийн "Талст маргад" ХХК-д 3999А, 11428А дугаар ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон хэсгийг илт хууль бусад тооцож, Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтсийн даргын 2007 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 1996 дугаар шийдвэрийн "Талст маргад" ХХК-д 12633Х, 12634Х, 12635Х, 12636Х, 12637Х, 12638Х дугаар бүхий хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон хэсгийг хүчингүй болгохыг Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтэст даалгасугай" гэж өөрчлөн, шийдвэр, магадлалын бусад заалтыг хэвээр үлдээсүгэй.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3-т зааснаар нэхэмжлэгч нараас тэмдэгтийн хураамжид төлсөн 70200 төгрөгийг төрийн сангийн 2611016627 дугаар данснаас шүүгчийн захирамжаар буцаан олгохыг дурдсугай.

ТАНХИМЫН ТЭРГҮҮН О.ЗАНДРАА

ШҮҮГЧ Ц.СУМЪЯА